



**WWF Mongolia
Programme Office**

Amar str-4,
Sukhbaatar district
khoroo-8
Ulaanbaatar, Mongolia

Tel:+976 11 311 659
Fax:+976 11 310 237
E-
mail:wwfmon@magicnet.mn
website: www.wwf.mn

Хэвлэлийн мэдээ

WWF-ийн байр суурь-Хариуцлагатай уул уурхай

“Ашигт малтмалын хууль дахь байгаль орчны асуудал” хэлэлцүүлэг болов.

2006 оны 4-р сарын 10, Улаанбаатар. УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчны яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран “Ашигт малтмалын хууль дахь байгаль орчны асуудал” хэлэлцүүлгийг 2006 оны 4-р сарын 10-нд зохион байгууллаа.

Хэлэлцүүлгээр ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга, үзэл баримтлал, уул уурхайн ашигт малтмалын олборлолт нөхөн сэргээлтийн өнөөгийн байдал, түүнд олон нийтийн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх талаар ярилцав.

Түүнчлэн ашигт малтмалын хуулийн хэрэгжилтэд орон нутагт тулгарч буй бэрхшээл, хяналтын тогтолцооны өнөөгийн байдал зэрэг асуудлаар харилцан санал солилцож, Засгийн газраас өргөн барьсан ашигт малтмалын хуультай холбогдуулан зөвлөмж гаргав.

ДБХС нь 4,7 сая гишүүн дэмжигчтэй, дэлхийн 100 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулдаг, байгаль орчныг хамгаалах, хүн төрөлхтөн байгаль орчинтойгоо зохицон амьдрах ирээдүйг бий болгох чиглэлээр ажилладаг, олон жилийн туршлагатай, төрийн бус олон улсын байгууллага юм.

Нэмэлт мэдээллийн талаар:

311-659 утсаар, эсвэл tuyachimeg@wwf.mn хаягаар хандана уу.